

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА**

1. “ЭКО НООС” ХХК-ийн товч танилцуулга
2. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт
  - Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
  - Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
  - Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
  - Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
  - Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
  - Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
4. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

## **1. “ЭКО НООС” ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2008 оноос төслийн баг монгол хонины ноосоор барилгын дулаан тусгаарлах материал үйлдвэрлэх чиглэлээр судалгаа хийж эхэлсэн бөгөөд үүний үндсэн дээр 2011 онд “Эко ноос” ХХК байгуулагдсан.

Бид дэлхийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж ноос ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий хонины ноосоор барилгын дулаан тусгаарлах материал үйлдвэрлэх иж бүрэн тоног төхөөрөмжтэй ноос угаах болон боловсруулах үйлдвэрүүдээ ашиглалтанд оруулаад байна. Энэ тоног төхөөрөмжүүд нь бүтээгдэхүүнийг түүхий эдээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх боловсруулалтын бүхий л үе шатыг орчин үеийн техник технологиор цогцоор нь гүйцэтгэнэ.

Мөн бид Олон Улсын Чанарын менежментийн моголцоо **ISO 9001:2015** болон Байгаль орчны менежментийн тогтолцоо **ISO 14001:2015** стандартууд болох **“НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО”**-г үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

### **Эрхэм зорилго:**

Эх орныхоо хөдөө аж ахуйн баялагийг ашиглан хүн, байгаль дэлхийд ээлтэй экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн брэнд болгох

### **Компанийн онцлог:**

Эх орныхоо хөдөө аж ахуйн шавхагдашгүй нөөц баялагийг орчин үеийн техник технологиор боловсруулан хүний эрүүл мэнд, байгаль дэлхийд ээлтэй экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаадын болон дотоодын зах зээлд нийлүүлж байгаа нь манай компанийн онцлог юм.

### **Бүтээгдэхүүний талаар:**

Хонины ноосоор хийсэн экологийн цэвэр бүтээгдэхүүн болох хонины ноосон барилгын дулаан тусгаарлах материал сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд эрэлт хэрэгцээ ихтэй байна.

Хонины ноосон барилгын дулаалгын материал нь галд дэмждэггүй, чийг шингээлт сайтай, хортон шавьжнаас хамгаалсан боловсруулалт хийгдсэн, дулаан болон дуу шингээлт сайн, хүний эрүүл мэндэд хортой химийн гаралтай бүтээгдэхүүн агуулаагүй, хамгийн гол нь экологийн цэвэр байгаль дэлхий болон хүний эрүүл мэндэд гаж нөлөө үзүүлдэггүйгээрээ бусад барилгын дулаалгын материалуудаас онцлог давуу талтай бүтээгдэхүүн юм.

## 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО, ТҮҮНИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт “Хонины ноосон барилгын дулаан тусгаарлах материал үйлдвэрлэх үйлдвэр”-ийн талбай нь далайн түвшнээс 707 м өндөрт өргөгдсөн харьцангуй нам газар байрлана. Дархан-Уул аймгийн нутгаар Хэнтийн нуруунаас эх авч Орхон голд цутгадаг Хараа гол урсдаг. Агаарын үнэмлэхүй их температур 7-р сард  $42.6\text{ }^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй бага температур нь 1-р сард  $-43,7\text{ }^{\circ}\text{C}$  хүрдэг. Жилд дунджаар 310-320 мм хур тунадас ордгийн 85-90% буюу 284-290 мм тунадас дулааны улиралд унадаг. Дархан хот нь 101.000 гаран хүн амтай үүнээс 80.000 орчим хүн ам нь Дархан хотод амьдардаг. Нийт хүн ам нь 64,6 хувийг 35 хүртэлх насны залуус эзэлдэг.

Компанийн байршлын хувьд стратегийн ач холбогдолтой Дархан-Уул аймгийн үйлдвэрлэлийн бүсэд байрлаж байгаагаараа давуу талтай. “Эко ноос” ХХК нь жилд 2389,5 тн бохир ноос боловсруулан, 1911,0 тн дулаан тусгаарлах материал үйлдвэрлэх хүчин чадалтай. Үйлдвэрээс хатуу болон шингэн гэсэн хаягдал гарна. Хатуу хог хаягдлыг Дархан сумын Нийтийн аж ахуй үйлчилгээний газартай гэрээ хийн ачуулах бөгөөд шингэн хаягдлыг Дархан сумын бохир усны төвийн шугам сүлжээнд нийлүүлнэ. Цаашид бид үйлдвэрийн технологийн бохир усыг цэвэршүүлэн үйлдвэрлэлд эргэн ашиглах технологийг үйлдвэрт нэвтрүүлэхээр судалгаа хийн ажиллаж байна. Ингэснээр үйлдвэрийн усны хэрэгцээ багасаад зогсохгүй, төвийн шугам нийлүүлэх бохир ус ч багасах ач холбогдолтой юм.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь үйлдвэрийн бүхий л шат дамжлагад хамаарах бөгөөд үйлдвэрээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, үйлдвэр явуулж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тодорхойлсон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд үндэслэн боловсруулав. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ нь дараах дэд зорилгуудыг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд, агаар, ус, хөрсөн бүрхэвч, ургамал, амьтан болон тухайн орчинд амьдарч, ажиллаж буй хүмүүст үйлдвэрийн барилгын засвар, түүний ашиглалтаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох, дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн бичгийг тодорхойлох, шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

Мөн 2022 онд цар тахал болон гаалийн асуудлаас шалтгаалан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа саатсан бөгөөд үүнээс үүдэн Байгаль орчны менежментийн ажлууд хийгдээгүй учир 2023 онд хийхээр төлөвлөн оруулав. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн болон хэрэгжилтийн тайланг жил бүр тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд хүргүүлж хянуулан зохих шийдвэрийг гаргуулж ажиллана..

**2023 ОНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах стандарт, аргачлал
<b>Хөрсөн бүрхэвчид</b>						
<p>Үйлдвэрийн талбайд үйлдвэрлэлийн явцад машин техникийн хөдөлгөөн, түүхий эд материал буулгах явцад ургамлан бүрхэвч дарагдах, устах хөрсөнд бүрхэвч суларч тоос дэгдэх</p>	<p>Хөрс ургамал талхлагдсан газрыг тохижуулах, нөхөн сэргээх ажлыг тухайн талбайд хийх орчныг цэвэрлэх, газрыг засан тохицуулах, нөхөн сайжруулах.</p> <p>Талхлагдсан газар нөхөн сэргээх ургамал тарих боломжгүй бол ногоон байгууламж байгуулж нөхөн сэргээх шаардлагатай</p>	<p>Ногоон байгууламж байгуулах талбайг цэвэрлэх, үйлдвэрийн үйлдвэрлэлийн явцад үүсэх хог хаягдлыг зайлуулах, талбайг цэвэрлэх</p>	-	300.0	<p>Дулааны улиралд үйлдвэрийн талбай дахь ногоон байгууламжийг сэргээн, шаардлагатай бол олон наст ургамал тариалах</p>	<p>Газрын тухай: зүйл 35-3.2.</p> <p>Зүйл 50-1.1, 1.2</p> <p>Газрын хэвлийн тухай хууль: Зүйл 41-1,2,3; Зүйл 55-1</p>
<p>Аваар ослоос үүдэлтэйгээр химийн</p>	<p>Асгаралт гарч болзошгүй химийн бодис агуулж буй савуудыг сав баглаа</p>	<p>Үйлдвэрт ашиглах химийн бодис, угаагч бодис хадгалах агуулах, бохир ус</p>	-	<p>Урьдчилан тооцох боломжгүй</p>	<p>Үйлдвэрт ашиглах химийн бодис ирэхээс өмнө агуулах</p>	<p>Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль: Зүйл 10-1,</p>

бодис болон бохир ус  
хөрсөнд алдагдах

боодлын бүрэн бүтэн  
байдлыг хангаж,  
зориулалтын агуулах  
саванд хадгалах,

Химийн болон угаагч  
бодис хадгалах  
агуулахыг тохижуулах  
галын хор, гал унтраах  
багаж суурилуулах

Бохир ус зайлуулах  
шугам хоолойг бүрэн  
бүтэн байдлыг шалгаж  
байх

Асгаралт болсон үед  
хэрэглэх шингээгч  
бодис, материалыг  
зохих газарт  
байршуулах

дамжуулах шугам  
байрлах цэг зэрэгт

Машин, техник  
технологид ашиглах  
шатах, тослох  
материал, бохир ус  
хадгалах агуулах сав

	<p>савыг бэлдсэн байх,</p> <p>Бохир ус зайлуулах, хураах, цэвэрлэх байгууламжид хаяг шугам хоолойн бүрэн бүтэн байдалд хяналт тавих</p>	<p>2, 3; Зүйл 11; Зүйл 12-2</p>
<p>Урьдчилан тооцох боломжгүй</p>	<p>Үйл ажиллагааны явцад бүрэн бүтэн байдлыг шалгах</p>	<p>Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байрлуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах, устгах журам. ЗГ-ын тогтоол №135. 2002,</p>

**Ургамлан нөмрөгт нөлөөлөх**

<p>Машин тоног төхөөрөмжөөс үүссэн тоосжилт, ургамлан бүрхэвчинд талхагдал бий болох</p>	<p>Үйлдвэрийн үйлдвэрлэлийн ажлын явцад машин техник, авто өргөгч зэрэг механизм нь олон салаа зам гаргалгүй тогтсон нэг замаар явах</p>	<p>Үйлдвэрийн түүхий эдийн гадаад, дотоод тээврийн хэрэгсэл үйлдвэрийн талбай доторх замууд</p>	<p align="center">-</p>	<p align="center">-</p>	<p>Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад</p>	<p>Байгалийн ургамлын тухай Зүйл 10, Зүйл 11.2, Зүйл 13.1,2,3</p> <p>Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008</p>
<p>Ургамлан бүрхэвч талхлагдаж болзошгүй</p>	<p>Ургамлан нөмрөгийг усалж тордох, даралт сайтай усаар шүрших замаар тоосжилтыг угааж арилгах</p>	<p>Үйлдвэрийн талбай</p>	<p align="center">0.1</p>	<p align="center">-</p>		<p>Байгалийн ургамлын тухай хууль</p>

**Дуу чимээний нөлөөлөл**

<p>Дуу чимээний гол эх сурвалж болох салхин цахилгаан станцын төхөөрөмж</p>	<p>Цахилгаан станцад хэрэглэгдэх бүх тоног төхөөрөмжийг үйлдвэрийн стандартад заасны дагуу ашиглах</p>	<p>Бүх машин, техник технологи, тоног төхөөрөмж үүнд хамаарна</p>	<p align="center">-</p>	<p>Үйлдвэрийн засвар, үйлчилгээний зардалд тусгах</p>	<p>Үйлдвэрийн үйл ажиллагааны ашиглалтын туршид</p>	<p>Дэлхийн банкны дуу чимээний стандарт, Монгол улсын Дууны октавын түвшний стандарт,</p>
	<p>Их дуу чимээ гаргадаг тоног төхөөрөмжид нь</p>		<p align="center">-</p>			<p>Хөдөлмөрийн хууль</p>

дуу чимээ намсгах арга  
хэмжээг авах

**Нийт төсөв**

**300.0**

Тайлбар: Үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах зардалд туссан урьдчилан тооцох боломжгүй зардлуудыг тухайн жилийн санхүүгийн тооцоонд заавал тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

## НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал /сая.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Барилгын засварын ажлын үед эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зүлэгжүүлэх, цэцэгжүүлэх	Үйлдвэрийн талбайд барилгын засварын ажлын үед эвдэрсэн элэгдсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай.	Цахилгаан станцын суурь бэлтгэх, угсрах, машин техникийн нөлөөлөлд өртсөн.	Урьдчилан тооцох боломжгүй тул төслийн нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөнд тусгаж өгөх шаардлагатай.	-	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хийж нөхөн сэргээлтийг жил бүр хийж байх	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага



## ДУЙЦУУЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал /сая.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Нийгмийн хариуцлагаа дээдлэн хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах	Өөрийн компанийн нэрэмжит талбайг бий болгон зүлэгжүүлэлт, моджуулалт, цэцэрлэгжүүлэлтийг хийн арчилгаа, усалгааг хийх	Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт	Урьдчилан тооцох боломжгүй тул төслийн нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөнд тусгаж өгөх шаардлагатай.	-	-	

## ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх хамгаалах, арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгаль орчныг хамгаалах, осол аюулаас сэргийлэх арга хэмжээ	Үйлдвэрийн бүх ажилчдад байгаль орчныг хамгаалах, химийн бодис алдагдахаас сэргийлэх, осол эрсдэлээс хамгаалах, галын аюулаас сээрэмжлэх талаарх зааварчилгааг тогтмол өгч, хатуу мөрдөж ажиллаж байх шаардлагатай.	Үйлдвэрийн бүх ажилчид үйлдвэрийн талбай болон оффист мөрдөх	-	-	Үйлдвэрийн ажлын өдрүүдэд өдөр бүр хэрэгжүүлэх  Холбогдох мэргэжлийн ажилтан байнга хяналт тавих	

<p>Аянга буух, цахилгаан хэрэгслийн гэмтэл, хэт халалт зэргээс үүдэн гал түймэр гарах</p>	<p>Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойг зохих журмын дагуу ашиглахыг ажилчдад тогтмол сургалтаар сургаж байх</p>	<p>Үйлдвэрийн бүх ажилчид үйлдвэрийн талбай болон оффист мөрдөх</p>
	<p>Тоног төхөөрөмж болон цахилгааны трансформаторт байрлуулсан аянга газардуулагчийн бүрэн бүтэн байдлыг байнга шалгах</p>	<p>Тоног төхөөрөмж, болон үйлдвэрийн талбайд байрлах цахилгаан трансформатор</p>
<p>Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх</p>	<p>Шинээр ажилд орж байгаа ажилчид эрүүл мэндийн үзлэгт орсон байх</p>	<p>Үйлдвэрийн бүх ажилчид эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдах</p>
	<p>Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга шинэчилж бүрэн бүтэн байлгах</p>	<p>Ажлын байранд ажилтан бэртэж гэмтэх, гэнэтийн аюул ослын үед ашиглах анхан шатны тусламжийн багаж хэрэгслээр</p>

		<p>Үйлдвэрийн ажлын өдрүүдэд өдөр бүр хэрэгжүүлэх</p> <p>Холбогдох мэргэжлийн ажилтан байнга хяналт тавих</p>	Гамшгаас хамгаалах тухай
-	-	Үйлдвэрийн ажлын өдрүүдэд өдөр бүр хэрэгжүүлэх	
-	жилийн төсвийн 1,5-аас доошгүй хувиар тооцно.	<p>Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад</p> <p>Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад</p>	Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль

		хангасан байх шаардлагатай.
	Үйл ажиллагааны зааврыг нарийн мөрдөх, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд байнга хяналт тавьж, шаардлагатай засвар үйлчилгээг хугацаанд нь хийх	Үйлдвэрийн талбайд байх бүх тоног төхөөрөмжүүд хамаарна
	Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, анхан шатны тусламжийн өгөх, осол аваарын үед авах арга хэмжээний талаарх сургалт сургалталчилгааг ажиллагсад байнга тогтмол хугацаанд олгох, хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах	Үйлдвэрийн бүх ажиллагсад хамрагдсан байх шаардлагатай
	Хонины ноосыг тээвэрлэх, ялгах үед хонины ноосноос гарах тоос үүсэж агаарт дэгдэх, ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	Ажлын бүсийн агаар тоосжих, чийгших, температур нь ихсэх нөлөөлөл үүсэхээр байгаа тул агаар сэлгэлтийн системийг

-		Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад	
-		Давтан сургалтуудыг тогтмол явуулах	
-	1.0	Тоосжилт ихсэх үед	MNS 4585:20169 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага  MNS5620:2016 Амьсгалын замыг

		ТОГТМОЛ ажиллуулж байх				хамгаалах хэрэгсэл
		Ажиллагсдад тоосноос хамгаалах хэрэгсэл олгож, хэрэглүүлж хэвшүүлэх	-		Тоосжилт ихэссэн үед	
	<b>Нийт</b>			<b>1.0</b>		

## ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх хамгаалах, арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Химийн бодис асгарах, ажилтны нүд, арьсны эсүүд гэмтэх	Химийн бодис алдагдахаас сэргийлэх, осол эрсдэлээс хамгаалах, зааварчилгааг тогтмол өгч, хатуу мөрдөж ажиллаж байх шаардлагатай.	Үйлдвэрийн бүх ажилчид үйлдвэрийн талбай болон оффист мөрдөх	-	Урьдчилан тооцох боломжгүй	Үйлдвэрийн ажлын өдрүүдэд өдөр бүр хэрэгжүүлэх  Холбогдох мэргэжлийн ажилтан байнга хяналт тавих	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам  Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2015

## ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг
<p>Үйлдвэрээс гарах хатуу хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл</p>	<p>Хог хаягдлыг аймгийн нийтийн аж ахуй үйлчигээний газартай байгуулсан гэрээний дагуу ачилт хийлгэх</p>	<p>Үйлдвэрийн талбай</p>	<p>56.0</p>
<p>Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл</p>	<p>Химийн бодисын сав баглаа боодлыг химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын 3.5.1-т заасны дагуу байгаль орчин, эрүүл ахуйн болон гамшгаас урьдчилан сэргийлэх улсын байцаагч нарыг байлцуулж зориулалтын цэгт устгана.</p>		
<p><b>Нийт</b></p>			

<b>Нийт зардал</b> /мян.төг/	<b>Хэрэгжүүлэх хугацаа</b>	<b>Баримтлах стандарт, аргачлал</b>
224.0	Улиралд нэг удаа, жилд дөрвөн удаа ачилтыг хийнэ.	Хог хаягдлын тухай стандарт
1000.0	Улиралд нэг удаа, жилд дөрвөн удаа устгал хийлгэнэ.	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
1224.0		



### 3. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон үйлдвэр ашиглах явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох, тэдгээрээс сэргийлэх зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм.

Хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. Үүнийг хэрэгжүүлэхдээ энд заасан бохирдуулах эх үүсвэрийг хянах Монгол улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандартууд шинэчлэгдвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах шаардлагатай. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорх асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

Таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар түүнээс хир зөрж байгааг, байгаль орчны хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг, нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихэсч байгааг, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно. Гүйцэтгэлийн менежментийн үр дүнг үйлдвэрээс гарч буй бохир ус, нийлүүлж буй ахуйн бохир ус, тоосжилтыг бууруулахад цэвэршүүлсэн газрын болон хөрсний чанар, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авахаас өмнөх агаар дахь тоосжилтын хэмжээ, арга хэмжээний дараах тоосжилтын хэмжээний харьцаа зэргийг үнэлнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, түүнд хийсэн дүгнэлт зэргийг жил бүр тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яаманд хүргүүлж хянуулан, дараа оны байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулна.

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал	Баримтлах стандарт	Дээд доод хязгаар
<b>Агаарын чанар</b>								
<b>Хүхрийн исэл SO2, нүүрстөрөгчийн дутуу исэл CO, азотын исэл NOx, Тоос (SPM), Хар тугалга Pb, Бензапирен, Тоосжилт</b>	Мг/м <sup>3</sup>	Тоосжилтын хэмжээг станцын хэмжээнд хэрэгжүүлж буй тоосны хяналтын цэгүүдэд, бусад үзүүлэлтүүдийг цахилгаан станцын салхины зонхилох чиглэлийн дагууд (ЗУ,БХ) 100,200,300,500 м зайд	Үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэхийн өмнөх үед нэг удаа цаашид агаарт бохирдол үүсэхгүй учир хэмжилтийг 5 жилд нэг удаа хийж агаарын чанарын өөрчлөлтийг харьцуулах	Тоосжилтын үзүүлэлтүүдийг станцын тоосжилтын хяналтын хэмжих горимоор хийх. Мэргэжлийн байгууллагаар үйлдвэрийн орчмын 2 цэгээс хийлгэх	45.0	90.0	Монгол улсын стандартууд, MNS(ISO) 4585:2007  “Агаарын чанар”, MNS 4585:1998 “Агаарын орчны чанарын үзүүлэлт” , MNS0017-2-3-16:1988 “Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам” Дээжлэхдээ MNS4584-98, MNS 3384:1982, MNS 4048:1988 баримтлах агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008	-
<b>Зүйлийн бүрэлдэхүүн биомасс</b>	Тоо, бодгаль, м <sup>2</sup> /гр	Хамгийн их нөлөөлөлд өртөж буй газраас	Үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэх үед нэг удаа цаашид 5 жилд нэг удаа хийх	Ургамлын дээжийг ургамлын судалгааны арга зүйн дагуу хийж гүйцэтгэх	300.0	300.0	Байгалийн ургамлын тухай хууль зүйл 10, 11-2, 13-1, 11-1, 2,3	

Ургамлан нөмрөгийн өөрчлөлтийг хянах мониторинг судалгаа хийх	Зүйл тоо, бодгаль, м <sup>2</sup> /гр	Үйлдвэрийн хашаанд ногоон байгууламжийн талбай	Жил бүр зуны улиралд Жил бүр хяналт хийх	Хяналт шалгалтын арга аргачлалын дагуу хийх	200.0	200.0		-
---	---------------------------------------	--	---	---	-------	-------	--	---

**Амьтан**

Тоо толгой, төрөл зүйлийн олон янз байдлыг судлах мониторинг хийх	Тоо толгой	Үйлдвэрийн талбайд	Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад 3 жилд нэг удаа	Амьтны аймгийн судалгааны арга зүйн дагуу хийж гүйцэтгэнэ	60.0	60.0	-	-
Хөрсний бичил биетэн микро организмуудыг хянаж, мониторинг судалгаа хийх	Зүйлийн тоо	Үйлдвэрийн талбайд	Үйлдвэр үйл ажиллагаа эхэлснээс хойш 3 жилд нэг удаа		60.0	60.0	-	-

**Хөрс**

рН, ялзмагийн агууламж, ялзмагт давхрагын зузаан, механик бүтэц, нийт азот, нийт фосфор, хүнд металлууд,	%, dS/m, мг/100г, см	Үйлдвэрийн талбайд	Үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэх үед нэг удаа, үйлдвэрлэлий	Хөрсний хяналт шинжилгээг УЦУБОШГ-аар үйлдвэрийн орчны 2 цэгээс хөрсний дээж авах	50.0	100.0	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 5850:2008, газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008,	-
--	----------------------	--------------------	---	---	------	-------	---	---

<b>1 см<sup>3</sup> дэх бактер, эмгэг төрүүлэгч бичил биетэн байгаа эсэх</b>			н явцад 3 жилд нэг удаа	стандартыг баримтлан авах			эвдэрсэн газрын ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918-2008	
<b>Ерөнхий хатуулаг</b>	Мг-экв/дм <sup>3</sup> , см, балл,	Ажилчдын ундны худаг	3 жилд 1 удаа үйлдвэрт ашиглах ус болох ундны уснаас	Усны дээжийг тогтоосон стандарт, дүрмийн дагуу авч шинжлэх	60.0	60.0	MNS (ISO) 5667-11:2000 усны чанар. Сорьц авах.	-
<b>Урвалын орчин /рН/</b>	мг/дм <sup>3</sup>	Гүний ухмал (суурийн бетон цутгах үед)					Бүлэг 11. Хөрсний уснаас сорьц авах заавар	
<b>Исэлдэх чанар</b>		Гүний худаг					MNS 4586:1998 Усны байгаль орчны чанар, Ерөнхий шаардлага.	
<b>Тунгалагшил</b>		(суурийн бетон зуурмагт ашиглах)					MNS (ISO) 5667-2:2001 Усны чанар. Сорьц авалт. Бүлэг 2. Сорьц авах техникийн талаарх гарын авлага	
<b>Өнгө</b>							MNS 3936:1986 Ундны ус. Хээрийн нөхцөлд сорьц авах ба шинжлэх арга	
<b>Үнэр</b>							MNS 3900:1986 Ундны ус. Амт, өнгө үнэр болон хуйлралтыг тодорхойлох	
<b>Амт</b>								
<b>Тунадас</b>								
<b>Анион /Cl-, SO<sub>4</sub>-, NO<sub>2</sub>-, NO<sub>3</sub>-, CO<sub>3</sub>-, HCO<sub>3</sub>-/</b>								
<b>Катион/Na+K+, Ca<sup>++</sup>, Mg<sup>++</sup>, H<sub>4</sub><sup>+</sup>, Fe<sup>++</sup>, Fe<sup>+++</sup>/</b>								
<b>Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зарцуулах урьдчилсан байдлаар тооцсон зардал</b>						<b>870.0</b>		-

**Хот суурины агаар мандал дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/**

№	Бодисын нэр	Хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/, мг/м <sup>3</sup>		
		Нэг удаагийн хамгийн их	Хоногийн дундаж	Хорын зэрэг
1	Азотын давхар исэл	0,0085	0,0085	2
2	Азотын хүчил /молекулаар/	0,4	0,4	2
3	Азотын хүчил /устөрөгчийн ионоор/	0,006	0,006	2
4	Аммиак	0,2	0,2	4
5	Амилын спирт	0,01	0,01	3
6	Ацетон	0,35	0,0085	4
7	Бензол	1,5	0,8	2
8	Гексан	0,1	-	3
9	Бутилын спирт	60	-	4
10	Нафталин	0,003	0,15	4
11	Хоргүй тоос	0,5	0,15	3
12	Хүхэрлэг ангидрид	0,5	0,15	3
13	Нүүрстөрөгчийн дутуу исэл	3,0		4
14	Толуол	0,6		3
15	Дөрвөн хлорт нүүрстөрөгч	4,0	2,0	2

16	Цууны ангидрид	0,1	0,03	3
17	Фенол	0,01	0,01	3
18	Фреон 11	100,0	10,0	4
19	Фреон 12	100,0	10,0	4
20	Фреон 21	100,0	10,0	4
21	Фреон 22	100,0	10,0	4
22	Хар тугалга болон түүний нэгдлүүд		0,0007	1
23	Хүхэрт устөрөгч	0,008	0,008	2
24	Хүхэрт нүүрстөрөгч	0,03	0,005	2

**1. Ажлын бүсийн агаар дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/**

№	Бодисын нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/		Хорын зэрэг
1	Азотын исэл	5,0		2
2	Аммиак	1,0		2
3	Ацетон	0,2		3
4	Бензол	5,0		2
5	Бутилын спирт	10,0		3
6	Борын ангидрид	5,0		3
7	Давсны хүчил	5,0		2
8	Дихлорбензол	20,0		4

9	Зэс	1,0
10	Идэмхий натри	0,3
11	Изопрен	40,0
12	Иод	1,0
13	Керосин	300,0
14	Никель	0,5
15	Нүүрстөрөгчийн исэл	10,0
16	Нүүрстөрөгчийн холимогтой хүхэрт устөрөгч	10,0
17	Нүүрстөрөгч	10,0
18	Мөнгөн ус	0,1
19	Тамхи	3,0
20	Дөрвөн этилт хар тугалга	0,0005
21	Толуол	50,0
22	Фенол	0,3
23	Хлор	1,0
24	Хар тугалга, түүний органик бус нэгдлүүд	0,01
25	Хлорын хоёрч исэл	0,1
26	Хлорт устөрөгч	5,0

	2
	2
	4
	2
	4
	2
	2
	2
	2
	2
	3
	1
	3
	3
	2
	1
	1
	2



27	Хүхэрт устөрөгч	10,0	2
28	Хүхэрт ангидрид	0,1	1
29	Хромын ангидрид	0,01	1
30	Мышьяк түүний ангидрид	0,3	2

## 2. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2007 стандарт

Гадаад орчны агаарын түгээмэл зарим бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх хэмжээ

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж, зөвшөөрөгдөх түвшин
Химийн нөлөөлөл			
Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> )	10 минутын дундаж		500
	20 минутын дундаж		450
	24 цагийн дундаж		20
	Жилийн дундаж		10
Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	30 минутын дундаж		60000
	1 цагийн дундаж		30000
	8 цагийн дундаж		10000
Азотын давхар исэл (NO <sub>2</sub> )	20 минутын дундаж		85
	24 цагийн дундаж		40
	8 цагийн дундаж		30

Озон ОЗ	8 цагийн дундаж		100
Том ширхэглэлт тоосонцор РМ- 10	24 цагийн дундаж		100
	Жилийн дундаж		50
Нарийн ширхэглэлт тоосонцор РМ- 2,5	24 цагийн дундаж		50
	Жилийн дундаж		25
<b>Физикийн нөлөөлөл</b>			
Дуу шуугиан: - Өдрийн цаг 07-23 -Шөнийн цаг 23-07	16 цагийн дундаж	дБА	60
	8 цагийн дундаж		45

**3. Унд, ахуйн хэрэгцээний усанд байж болох химийн хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ**

№	Үзүүлэлтүүдийн нэр	Дээд хэмжээ мг/дм <sup>3</sup>
1	Анзан	0,25
2	Биндэр	0,002
3	Зөөлөн цагаан	0,01
4	Мөнгө	0,05
5	Нитрат	10,0
6	Полиакриламидын үлдэгдэл	2,0
7	Селен	0,001
8	Стронц	2,0

- |    |                                |
|----|--------------------------------|
| 9  | Хар тугалга                    |
| 10 | Хромын нийт хэмжээ             |
| 11 | Хөнгөн цагааны үлдэгдэл хэмжээ |
| 12 | Хүнцэл                         |
| 13 | Цинанид                        |
| 14 | Фтор                           |
| 15 | Зэс                            |
| 16 | Кальцийн ион                   |
| 17 | Магнийн ион                    |
| 18 | Марганец                       |
| 19 | Сульфат ион                    |
| 20 | Нийт төмрийн хэмжээ            |
| 21 | Фенолын нэгдлүүд               |
| 22 | Фосфатын ион                   |
| 23 | Нийт хатуулаг                  |
| 24 | Хлоридын ион                   |
| 25 | Хуурай үлдэгдэл                |
| 26 | Цайрын ион                     |

0,03

0,05

0,5

0,05

0,01

0,7-1,5

1,0

100,0

30,0

0,1

500,0

0,3

0,002

3,5

7,0

350,0

1000,0

5,0

**2023 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ажилтны нэр	Албан тушаал	Хариуцах ажил үүрэг	Ажил үүргийн цар хүрээ
Ё. Батдорж	Үйлдвэрийн дарга	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хариуцагч	Үйлдвэрийн тоног төхөөрөмж дээр ажиллаж буй дамжлагын ажилчид, тоног төхөөрөмжүүд
		Ерөнхий зохион байгуулалт	Үйлдвэрийн бүх цех, ажилчид
Б. Батбилэг	ХАБЭА-н ажилтан	Осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэгч	Үйлдвэрийн бүх ажилчид
Э.Энхзул	Үйлдвэрийн няравр	Химийн бодисын аюулгүй байдлыг хариуцагч	Химийн бодистой харьцах ажилчид, химийн бодисын агуулах
Б. Рэнцэндаваа	Үйлдвэрийн манаач	Хог хаягдлыг хариуцан ажиллах	Үйлдвэрийн хогийн цэг

**4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ  
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ**

2023 онд байгаль орчны менежментийн хүрээнд нийт 2.394,0 мянган төгрөг зарцуулахаар тооцож гаргалаа. Үүнээс сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 300,0 мянган төгрөг, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 1224,0 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 870,0 мянган төгрөгийг тус тус тусгасан байна. Төлөвлөгөөнд тусгагдсан урьдчилан тооцох боломжгүй зардлуудыг хэрэгжилтийн тухай бүрт нь тооцож дараа жилийн байгаль орчны менежментийн тайлан болон жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар орон нутгийн байгаль орчны газарт хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч нарт тайланг жил тутамд хүргүүлнэ.